



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 1/07

Хажуу шинэ ус

Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 63 дугаар зүйлийн 63.1, 63.3 дахь заалт, Орон Нутгийн Хөгжлийн Сангийн үйл ажиллагааны 6.2 дэх журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ түүний ач холбогдлыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх аргазүйн зөвлөмж өгөх, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|                      |                 |                                            |
|----------------------|-----------------|--------------------------------------------|
| Ажлын хэсгийн ахлагч | Д.Сарангэрэл    | (Засаг даргын орлогч)                      |
| Нарийн бичгийн дарга | Э.Сувдмаа       | (Халамжийн мэргэжилтэн)                    |
| Гишүүдэд             | Т.Цэрэнчунт     | (ХАА-н мэргэжилтэн)                        |
|                      | Н.Ганбат        | (Санхүү албаны дарга)                      |
|                      | Д.Мандахцацрал  | (Байгаль орчны<br>хяналтын улсын байцаагч) |
|                      | Л.Батбаатар     | (4-р багийн засаг дарга)                   |
|                      | Г.Нандин-Эрдэнэ | (4-р багийн иргэн)                         |

2. Иргэдэд төсвийн тухай хууль тогтоомжийг сурталчилан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудад олон нийтийн оролцоог жигд хангаж зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2021 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн А/06 тоот захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.МӨНХ-АМГАЛАН

